

САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

2022 оны 10 сарын 28-ны өдөр

№ СТГ-22/01

Улаанбаатар хот

2023 оны 02 сарын 01

Нэг.Нийтлэг үндэслэл

2023/08.

1.1. Гэрээний талууд

1.1.1. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 19 байр, 12 дугаар давхар хаягт байрлах, улсын бүртгэлийн 9011680088, регистрийн 6196233 дугаартай “**Ди Би Эм лизинг**” ХХК (цаашид “**Түрээслүүлэгч**” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Н.Цэрэнсодном;

1.1.2. Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, УС 15, 1-0 тоотод байрлах, улсын бүртгэлийн 9012001030, регистрийн РД:6021646 дугаартай “**Амгалан дулааны станц**” ТӨХК (цаашид “**Түрээслэгч**” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө;

1.1.3. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Ж.Самбуугийн гудамж-30, Бага тойруу 14201-д байрлах улсын бүртгэлийн 9070007079, регистрийн 9128808 дугаартай Монгол Улсын “**Эрчим хүчний зохицуулах хороо**” (цаашид “**ЭХЗХ**” гэх) түүнийг төлөөлж дарга Э.Түвшинчулуун;

1.1.4. Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 17060-д байрлах байрлах улсын бүртгэлийн 9011018150, регистрийн 2699877 дугаартай “**Диспетчерийн үндэсний төв**” (цаашид “**ДҮТ**” гэх) ТӨХК түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Балжинням;

1.1.5. Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Ф.Энгельсийн гудамж-18 хаягт байрлах улсын бүртгэлийн 9012001011, регистрийн 2688476 дугаартай “**Улаанбаатар дулааны сүлжээ**” (цаашид “**УБДС**” гэх) ТӨХК түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Баярсайхан.


1.2. Энэхүү Санхүүгийн түрээсийн гэрээ (цаашид “**Гэрээ**” гэх)-г Иргэний хуулийн хорин зургаадугаар бүлэг, Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Монгол Улсын Эрчим Хүчний сайдын 2022 оны 08 дугаар 25-ны өдрийн а/3258 тоот албан хүсэлт, Түрээслэгчийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 01/380 тоот албан хүсэлт, УБДС-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 21 дугаартай тогтоол, ДҮТ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 24 дугаартай тогтоол, Түрээслүүлэгчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаартай шийдвэр, Түрээслэгчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 27 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн байгуулав.

1.3. Гэрээний зорилго нь Түрээслүүлэгч нь Түрээслэгчийн сонгосон ажил гүйцэтгэгчээс хүлээлгэн өгөх Түрээсийн зүйлийг Гэрээнд заасан нөхцөлөөр түрээслүүлэх, Түрээслэгч түрээсийн төлбөрийг Түрээслүүлэгчид төлөх, ЭХЗХ, ДҮТ, УБДС талууд нь Түрээслэгчийн эргэн төлөлтийг хангах санхүүгийн чадавхыг бүрдүүлэх үүргийг хүлээх, Гэрээний хугацаа дуусаж төлбөрийн үүрэг бүрэн хангагдсан нөхцөлд Түрээсийн зүйлийн өмчлөх эрхийг Түрээслэгчид шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр.Нэр томьёоны тайлбар

2.1. Энэхүү Гэрээнд холбогдох эрх зүйн баримт бичгийг дараах нэр томьёогоор тодорхойлж, тайлбарлав. Үүнд:

2.1.1. “Төсөл” гэж: Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаартай тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогын 2 дугаар хавсралтын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.1.3-т заасан үйл ажиллагааны дагуу “Амгалангийн дулааны станцыг өргөтгөн Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны хэрэглээний өсөлтийг хангах”-аар Түрээслэгчийн хүчин чадлыг 116МВт (100Гкал/цаг)-аар нэмэгдүүлэх ажлыг;



Түрээслэгч

ЭХЗХ

УБДС

ДҮТ

2.1.2. “Тариф” гэж: Түрээслэгчийн Гэрээний эргэн төлөлтийг хангахад баталгаа болгон ЭХЗХ-ны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 444 дугаартай тогтоолоор баталсан “Амгалан дулааны станц ТӨХК-ийн худалдах дулааны тариф”-ыг;

2.1.3. “Чадлын тариф” гэж: ЭХЗХ-ны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 444 дугаартай тогтоолоор баталсан “Амгалан дулааны станц ТӨХК-ийн сар бүр тогтмол худалдах дулааны тарифыг;

2.1.4. “Энергийн тариф” гэж: ЭХЗХ-ны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 444 дугаартай тогтоолоор баталсан “Амгалан дулааны станц ТӨХК-ийн үйлдвэрлэсэн дулаан худалдах тарифыг;

2.1.5. “Индексжүүлэлт” гэж: ЭХЗХ-ны 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 432 дугаартай тогтоолоор баталсан “Амгалан дулаан станц” ТӨХК-ийн худалдах дулааны тарифыг индексжүүлэх үзүүлэлтийг;

2.1.6. “Дулааны төлбөр” гэж: Гэрээний 2.1.3 болон 2.1.4-т заасан тарифын дагуу “УБДС”-иас Түрээслэгчид шилжүүлэх төлбөрийг;

2.1.7. “Бусад орлого” гэж: Түрээслэгчийн үндсэн үйл ажиллагаанаас бусад хэлбэрээр олсон бүхий л орлогыг;

2.1.8. “Горим” гэж: ДҮТ-өөс боловсруулж Эрчим хүчний дэд сайдаар батлуулсан “Улаанбаатар хотын дулаан хангамжийн 2022-2027 онуудын өвлийн их ачааллын горим”-ыг;

2.1.9. “Дулаан нийлүүлэх гэрээ” гэж: Тариф, Горимын дагуу Түрээслэгч болон УБДС-н хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан 120/2022 дугаартай “Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ”-г;

2.1.10. “Төсөл хэрэгжүүлэх гэрээ” гэж: Төслийг хэрэгжүүлэх зорилгоор Эрчим хүчний яам, ЭХЗХ болон Түрээслүүлэгчийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан ... дугаартай Төсөл хэрэгжүүлэх хамтран ажиллах гэрээг;

2.1.11. “Төлбөр тооцооны гэрээ” гэж: Гэрээний эргэн төлөлтийг гүйцэтгэхэд чиглэсэн төлбөр тооцооны гүйлгээг хийхээр Монгол Улсын Хөгжлийн банк /цаашид “МУХБ” гэх/, Түрээслүүлэгч, Түрээслэгч, УБДС нарын хооронд 2022 оны 12 дугаар сарын 06-ын өдөр байгуулсан Төлбөр тооцооны хамтран ажиллах гэрээг;

2.1.12. “Санхүүгийн түрээсийн олголт” гэж: Түрээслэгчийн сонгосон түрээсийн зүйлийг нийлүүлэгч буюу ажил гүйцэтгэгч “Хунан индустриал экүйпмент инсталейшн” ХХК болон Түрээслүүлэгч, Түрээслэгчийн хооронд байгуулсан Гэрээний 4.1-т заасан Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээний нөхцөлийн дагуу Түрээслүүлэгчээс нийлүүлэгч буюу ажил гүйцэтгэгчид шилжүүлсэн төлбөрийг.

Гурав. Гэрээний үндсэн нөхцөл

3.1. Санхүүгийн түрээсийн хэмжээ: **55,822,154,239** /тавин таван тэрбум найман зуун хорин хоёр сая нэг зуун тавин дөрвөн мянга хоёр зуун гучин ес/ төгрөг хүртэлх.

3.2. Түрээсийн хүү: (SOFR 90 хоног)¹ + 9.80%

3.3. Гэрээний 3.2-т заасан “SOFR 90 хоног”-ын хөвөгч хүүг улирал тутам шинэчлэх бөгөөд тухайн шинэчлэн тогтоосон хүүг дараагийн улиралд төлөх хүүгийн төлбөрт мөрдөж ажиллана.


3.4. Гэрээний хугацаа: 5 /тав/ жил

3.5. Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: Санхүүгийн түрээсийн эхний олголт хийсэн өдрөөс хойш 3 /гурав/ сар.

3.6. Түрээсийн төлбөр: Үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлнө.

3.7. Гэрээний 3.3-т заасны дагуу түрээсийн хүүг шинэчлэх, Санхүүгийн түрээсийн олголт хийхтэй холбоотойгоор Гэрээний Хавсралт 2-д заасан эргэн төлөлтийн хуваарийг

¹ (SOFR 90 хоног) гэдэг нь АНУ-ын овернайт банк хоорондын захын хөвөгч хүү бөгөөд www.newyorkfed.org цахим хуудаст зарласан тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хүүг хэлнэ.



Түрээслэгч

ЭХЗХ

УБДС

ДҮТ

Хавсралт 3-т заасан маягтын дагуу зөвхөн Түрээслүүлэгч болон Түрээслэгч нарын хооронд тухай бүр баталгаажуулан өөрчилнө.

3.8. Алданги: Түрээслэгч нь түрээсийн үндсэн төлбөрийг Гэрээний Хавсралт 2-т заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үндсэн төлбөрийн дүнгээс Гэрээний 3.2-т заасан хүүг хоногт шилжүүлсэн хувиар тооцоолсон алдангийн хэмжээгээр зөрчил арилах хүртэл хугацаанд тооцон төлөх.

3.9. Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу Түрээслэгчийн төлөх түрээсийн хүүг Монгол банкнаас тогтоосон Банк, Эрх бүхий хуулийн этгээдийн зээл, хадгаламжийн хүү бодох, тооцох аргачлалын дагуу тооцоолно.

Дөрөв.Түрээсийн зүйл

4.1. Түрээсийн зүйл нь Түрээслэгчийн сонгосон ажил гүйцэтгэгч болон Эрчим хүчний яамны хооронд 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан “ЭХА-024/2022” дугаартай түлхүүр гардуулах нөхцөлтэй “Амгалан дулааны станцыг өргөтгөн Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны хэрэглээний өсөлтийг хангах” барилга угсралтын ажлыг гүйцэтгэхээр захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ /цаашид “Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээ” гэх/ болон тус гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан “Эрчим хүчний яам”, Түрээслүүлэгч, Түрээслэгч болон “Хунан индустриал экүйпмент инсталэйшн” ХХК-ийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан “ЭХА-024/2022-01” дугаартай Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээний нэмэлт, өөрчлөлтийн гэрээнд тус тус заасан буюу энэхүү Гэрээний Хавсралт 1-д заасан ашиглалтын явцад үндсэн шинж чанараа алддаггүй биет эд хөрөнгө болох QXF116-1.6/130/70 маркийн дулааны эрчим хүч үйлдвэрлэх 1 ширхэг зуух, 4 ширхэг үнс хадгалах сав болон түүнд холбогдох бусад иж бүрдэл тоноглол, тоног төхөөрөмжийг хэлнэ.

4.2. Түрээсийн зүйл нь Түрээслэгчийн тусгай захиалгаар, зөвхөн түүний хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зориулалттай гүйцэтгэсэн QXF116-1.6/130/70 маркийн зуух, 4 ширхэг үнс хадгалах сав болон түүнд холбогдох бусад иж бүрдэл тоноглол, тоног төхөөрөмж тул Түрээслэгчийн санаачилгаар ямар ч нөхцөлд Түрээслүүлэгчид буцаахгүй болохыг Талууд харилцан тохиролцов.

4.3. Түрээсийн зүйлийг Түрээслэгчид шилжүүлэх үйл ажиллагаа нь Гэрээний 4.1-д заасан Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээний нөхцөлийн дагуу зохицуулагдана.

4.4. Түрээсийн зүйлийн баталгаат хугацаанд хийх засвар, үйлчилгээ нь Гэрээний 4.1-д заасан Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээнд заасан харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу зохицуулагдах бөгөөд баталгаат хугацаа дуусгавар болсны дараах үеийн засвар, үйлчилгээг Түрээслэгч дангаараа бие даан гүйцэтгэх үүрэгтэй.

4.5. Түрээслэгч нь Гэрээний хугацаанд Түрээсийн зүйлийг өөрийн санхүүгийн тайлан балансад бүртгэнэ.

Тав.Түрээслүүлэгчийн эрх, үүрэг


5.1. Түрээслүүлэгч нь дараах эрхтэй:

5.1.1. Гэрээний Хавсралт 1-д заасан Түрээсийн зүйлийг Гэрээний үүрэг бүрэн биелэгдэх хүртэл хугацаанд өөрийн өмчлөлд байлгах;

5.1.2. Санхүүгийн түрээсийн олголт хийсэн өдрөөс эхлэн нийт олголт хийсэн үлдэгдэл дүнгээс Гэрээний 3.2-т заасан түрээсийн хүүг хоногт шилжүүлснээр тооцож төлөхийг Түрээслэгчээс шаардах;

5.1.3. Түрээслэгчээс Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд төлбөрөө төлөхийг шаардаж, түүнчлэн Түрээслэгчийн үйл ажиллагааны бусад зардлыг гаргахаас өмнө тэргүүн ээлжинд Гэрээний эргэн төлөлтийг хуваарийн дагуу хугацаанд нь гүйцэтгэж байхыг Түрээслэгчээс шаардах;

5.1.4. Түрээслэгчийн дулааны эрчим хүч борлуулсан төлбөрийг Түрээслэгчийн МУХБ дахь 3600001547 тоот харилцах дансанд шилжүүлж байхыг УБДС-ээс шаардах;



Түрээслэгч

ЭХЗУ

УБДС

ДУТ

5.1.5. Түрээслэгчийн МУХБ дахь 3600001547 тоот харилцах данснаас Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу үндсэн төлбөр, хүүгийн төлбөр болон алдангийг Түрээслүүлэгч нь МУХБ дахь өөрийн 3600005414 тоот харилцах дансанд шууд шилжүүлэх байдлаар төлбөр тооцоог гүйцэтгүүлэх;

5.1.6. Түрээсийн зүйлийг зориулалтын дагуу ашиглаж, хэвийн ажиллаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих, битүүмжлэх, түүнд холбогдуулж түрээсийн зүйл байгаа газар болон Түрээслэгчийн үйл ажиллагаа хэрэгжүүлж буй газруудад саадгүйгээр нэвтрэх;

5.1.7. Түрээсийн зүйлийн хэвийн бус элэгдэл, эвдрэл гэмтэл, сервис үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүй зэрэг зөрчлийг илрүүлсэн тохиолдолд зөрчлийг шаардан арилгуулах;

5.1.8. Түрээсийн зүйлийг иж бүрэн даатгалд даатгуулахыг шаардах;

5.1.9. Гэрээний хугацаанд Түрээслэгчийн сар бүрийн үйлдвэрлэл, борлуулалтын гүйцэтгэлийн дэлгэрэнгүй тайлан, Түрээслэгчийн аудитлагдсан санхүүгийн тайлан, Түрээсийн зүйлийн ашиглалтын дэлгэрэнгүй тайлан, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө /бизнес төлөвлөгөө/, төсөв холбогдох бусад мэдээллийг шаардах;

5.1.10. Түрээсийн зүйл болон барьцаа хөрөнгөнд аливаа засвар хийх, эд хөрөнгийн даатгалд даатгуулах болон түрээсийн зүйлийг Түрээслэгчид шилжүүлэхтэй холбогдох гарах зардал болон бусад зардлыг Түрээслэгчээр төлүүлэх;

5.1.11. Түрээслэгчийн байгууллага нийлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулах, хувь эзэмшигчдийн бүтэц, эзэмшиж буй хувьд өөрчлөлт орох, татан буугдах, эрх зүйн байдал өөрчлөгдөх, нэрээ солих, оршин байгаа газраа өөрчлөх эсхүл эдгээр нөхцөл байдал бий болж болзошгүй тохиолдолд уг асуудлыг хуанлийн 30 /зуч/-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэхийг Түрээслэгчээс шаардах;

5.1.12. Түрээслэгч Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах;

5.1.13. Хууль болон Гэрээнд заасан үндэслэлээр түрээсийн зүйлийг түр буцаан авах буюу битүүмжлэх, гэрээг цуцлах, үүнтэй холбогдсон зардлыг Түрээслэгчээс нөхөн төлүүлэхээр шаардах;

5.1.14. Түрээслэгч Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Гэрээний үүргийн биелэлтийг хуульд заасан журмаар бүрэн хангуулах;

5.1.15. Түрээслүүлэгч нь энэхүү Гэрээ, түүнд холбогдох бусад гэрээний үүргийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээлэл болон бусад холбогдох мэдээлэл, баримт бичгийг Түрээслэгч болон ЭХЗХ, УБДС, ДҮТ-с шаардах;

5.1.16. Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар нэмэлт гэрээ байгуулах болох хөрөнгө барьцаалахыг Талуудаас шаардах;

5.1.17. Түрээслэгчийн Гэрээний эргэн төлөлтийг бүрэн хангуулахаар Гэрээний 2.1.2-т заасан хамгийн багадаа 30%-иас багагүйгээр ихэсгэж баталсан Тарифыг цуцлахгүй, хүчингүйд тооцохгүй, мөн багасгахгүй, бууруулахгүй байх, Гэрээний эргэн төлөлтийг бүрэн хангах хэмжээгээр ихэсгэх болон холбогдох бусад зохицуулалт хийхийг, Гэрээний төлбөрийн үүрэг бүрэн хангагдах хүртэлх хугацаанд ЭХЗХ-оос шаардах;

5.1.18. Тарифыг ЭХЗХ болон бусад эрх бүхий байгууллагаас цуцалсан, хүчингүйд тооцсон, мөн багасгасан, бууруулсан тохиолдолд Түрээслүүлэгч болон Түрээслэгчид учирсан хохирол, Түрээслэгчийн төлөх алдангийг ЭХЗХ-оос гаргуулах, шаардлагатай тохиолдолд ДҮТ-өөс гаргуулах, түүний үүргийн гүйцэтгэлийг шаардах;

5.1.19. Түрээслэгч нь Гэрээний 2.1.2-т заасан Тарифын дагуу Гэрээний төлбөрийн үүргээ цаашид бүрэн биелүүлэх боломжгүй болсон, эсхүл уг шалтгаанаар эргэн төлөлтийн зөрчил үүсгэсэн тохиолдолд ЭХЗХ-ны хамгийн багадаа 30%-иас багагүйгээр ихэсгэж баталсан Тарифыг Гэрээний эргэн төлөлтийг бүрэн хангах хэмжээгээр ихэсгэх хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн батлахыг ЭХЗХ-оос шаардах;

5.1.20. Горимын дагуу Түрээслэгчийн дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээг Гэрээний төлбөрийн үүрэг бүрэн хангагдах хүртэлх хугацаанд бууруулахгүй, цуцлахгүй, хүчингүйд тооцохгүй байхыг ДҮТ-өөс шаардах;



Түрээслэгч
[Signature]

ЭХЗХ
[Signature]

УБДС
[Signature]

ДҮТ
[Signature]

5.1.21. Түрээслэгч нь баталсан Горимын дагуу Гэрээний төлбөрийн үүргээ цаашид бүрэн биелүүлэх боломжгүй болсон, эсхүл уг шалтгаанаар эргэн төлөлтийн зөрчил үүсгэсэн тохиолдолд Горимд заасан Түрээслэгчийн үйлдвэрлэх дулааны хэмжээг ихэсгэх болон холбогдох бусад арга хэмжээ авах хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн батлуулахыг ДҮТ-өөс шаардах;

5.1.22. Горимыг ДҮТ болон бусад эрх бүхий байгууллагаас цуцалсан, хүчингүйд тооцсон, мөн багасгасан, бууруулсан тохиолдолд Түрээслүүлэгч болон Түрээслэгчид учирсан хохирол, Түрээслэгчийн төлөх алдангийг ДҮТ-өөс гаргуулах, түүний үүргийн гүйцэтгэлийг шаардах;

5.1.23. Дулаан нийлүүлэх гэрээний дагуу дулаан худалдаж авах төлбөр тооцоог Гэрээний төлбөрийн үүрэг бүрэн хангагдах хүртэл хугацаанд саадгүй, шуурхай байдлаар, зөвхөн Түрээслэгчийн МУХБ дахь 3600001547 тоот харилцах дансанд шилжүүлж байхыг УБДС-ээс шаардах;

5.1.24. Гэрээний Хавсралт 2-т заасан Түрээслэгчийн эргэн төлөлтийн хуваарьт хугацаа болохоос өмнө Чадлын тарифаар тогтоосон дулааны төлбөрийг Гэрээний 5.1.22-т заасан Түрээслэгчийн дансанд сар бүр, тогтмол шилжүүлэх, Энергийн тарифаар тогтоосон дулааны төлбөрийг үйлдвэрлэж нийлүүлсэн дулааны хэмжээгээр тухай бүр шилжүүлж, Түрээслэгчийн эргэн төлөлтийг хангуулахыг УБДС-ээс шаардах;

5.1.25. Түрээслэгчийн Гэрээний төлбөрийг төлөх санхүүгийн чадварт нь нөлөөлөх эрсдэл үүссэн, эсхүл үүсэх нөхцөл байдал бий гэж үзсэн тохиолдолд уг асуудлыг Түрээслүүлэгчид нэн даруй мэдэгдэхийг Түрээслэгч болон ЭХЗХ, ДҮТ, УБДС-ээс шаардах;

5.1.26. Тариф, Горимын хугацааг сунгах, Түрээслэгчид холбогдох тариф, горимыг ихэсгэхээр шинэчлэн, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан тохиолдолд тухайн тариф, горимын дагуу УБДС нь Түрээслэгчтэй байгуулсан Дулаан нийлүүлэх гэрээг шинэчлэн байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулахыг Түрээслэгч болон УБДС-ээс тус тус шаардах;

5.1.27. УБДС болон Түрээслэгч нь энэхүү Гэрээнд зааснаас бусад шалтгаан, нөхцөлөөр Дулаан нийлүүлэх гэрээг цуцалсан, татгалзсан, дуусгавар болгосон, шинэчлэн байгуулсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсхүл УБДС нь дулааны төлбөрийг Гэрээний 5.1.22-т заасан Түрээслэгчийн дансанд шилжүүлээгүй, хугацаа хэтрүүлсэн, бүрэн шилжүүлээгүй зэрэг Түрээслэгчийн энэхүү Гэрээний эргэн төлөлтийг хангах нөхцөл боломжийг бүрдүүлээгүй аливаа зөрчлийг санаатай болон болгоомжгүй байдлаар гаргасан тохиолдолд Түрээслэгчийн төлөх алданги болон Түрээслүүлэгч, Түрээслэгчид учирсан хохирлыг хариуцаж УБДС-ээс гаргуулах, түүний үүргийн гүйцэтгэлийг шаардах;


5.1.28. Түрээслэгчийн үйл ажиллагаанд холбогдох бүхий л мэдээлэл, баримт бичгийг ЭХЗХ, ДҮТ, УБДС-ээс тогтоосон хугацаанд гаргаж өгөхийг шаардах;

5.1.29. Түрээслэгч болон ЭХЗХ, ДҮТ, УБДС нар нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүрэг болон Түрээслэгчийн төлбөрийн үүргийг хангахтай холбоотой Дулаан нийлүүлэх гэрээ, Төсөл хэрэгжүүлэх гэрээ, Төлбөр тооцооны гэрээ, түүнд холбогдох хууль тогтоомж, шийдвэр, гэрээнд заасан үүргээ тус тус биелүүлээгүйгээс Түрээслэгч нь төлбөрийн зөрчил үүсгэвэл хуримтлагдсан алданги болон Түрээслүүлэгч, Түрээслэгчид учирсан хохирлыг буруутай этгээдээс гаргуулахаар шаардах;

5.1.30. Гэрээнд заасан нөхцөлөөр Дулаан нийлүүлэх гэрээ болон Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээг шинэчлэн байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд зөвшөөрөл олгох эрхтэй.

5.1.31. Түрээслэгч, ЭХЗХ, ДҮТ, УБДС-ээс энэхүү Гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомж, гэрээ, шийдвэрт заасан үүргээ биелүүлэхийг шаардах;

5.1.32. Тарифын дагуу Түрээслэгч нь Гэрээний эргэн төлөлтийг хангах боломжгүй болсон тохиолдолд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулахыг ЭХЗХ-оос шаардах.



Түрээслэгч

ЭХЗХ

УБДС

ДҮТ

5.1.33. Түрээслэгчийн Бусад орлогоор Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах, Бусад орлогыг Түрээслэгчийн МУХБ дахь 3600001547 тоот харилцах дансанд төвлөрүүлж байхыг Түрээслэгчээс тус тус шаардах;

5.1.34. Түрээслэгчийн дансны үлдэгдэл Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарьт хугацааны дагуу төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд Төлбөр тооцооны гэрээний дагуу дансыг битүүмжлэх, үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар дансны үлдэгдлийг шууд шилжүүлж авах;

5.1.35. Холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасан бусад эрх.

5.2. Түрээслүүлэгч нь дараах үүрэгтэй:

5.2.1. Түрээсийн зүйлийг Гэрээнд заасан нөхцөлөөр түрээслүүлэх;

5.2.2. Түрээсийн зүйлийг ажил гүйцэтгэгчээс хүлээлгэн өгөх үүргийн гүйцэтгэлийг Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээнд заасан нөхцөлийн дагуу шийдвэрлүүлэх;

5.2.3. Түрээсийн төлбөрийн үүрэг бүрэн хангагдсан нөхцөлд түрээсийн зүйлийг Түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэх;

5.2.4. Түрээслүүлэгч Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс болж Түрээслэгчид учирсан хохирлыг нөхөн төлөх;

5.2.5. Тарифыг ихэсгэхтэй холбоотойгоор шийдвэр гаргах шаардлагатай болсон тохиолдолд Гэрээний төлбөрийн үүргийг хангуулахтай холбоотой эргэн төлөлтийн тооцооллыг ЭХЗХ, ДҮТ, УБДС-д хүргүүлэх;

5.2.6. Түрээсийн зүйлтэй холбогдсон аливаа төлбөр тооцоо, бүртгэлийг үнэн зөв гүйцэтгэх.

Зургаа.Түрээслэгчийн эрх, үүрэг

6.1. Түрээслэгч нь дараах эрхтэй:

6.1.1.Бүрэн бүтэн байдлын болон хэвийн үйл ажиллагааны шаардлага хангасан түрээсийн зүйлийг эзэмшил, ашиглалтандаа шилжүүлэн авахыг Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээнд заасан ажил гүйцэтгэгч буюу нийлүүлэгчээс шаардах;

6.1.2.Гэрээний үүргийн гүйцэтгэл бүрэн хангагдсан тохиолдолд түрээсийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлэн авах;

6.1.3.Гэрээний 4.1-т заасан гэрээнд харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу ажил гүйцэтгэгчээс хүлээлгэн өгч байгаа түрээсийн зүйл нь эрхийн болон биет байдлын доголдолтой бол уг доголдлыг арилгуулахаар ажил гүйцэтгэгчээс шаардах;

6.1.4.Гэрээний эргэн төлөлт хийхэд шаардлагатай нөхцөл байдлыг бүрдүүлж Гэрээний эргэн төлөлт хийж дуусах хүртэлх хугацаанд Горимыг багасгахгүй байх, ихэсгэж батлахыг ДҮТ-өөс шаардах;

6.1.5.Гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомж, шийдвэр, гэрээнд заасан үүргээ ДҮТ биелүүлээгүйгээс Түрээслэгч Гэрээнд заасан үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд алданги, хохирлыг төлөх үүргийг ДҮТ-өөс шаардах;


6.1.6.Дулаан нийлүүлэх гэрээнд заасны дагуу Чадлын тарифын төлбөрийг Гэрээний төлбөрийн үүрэг бүрэн хангагдах хүртэл хугацаанд сар бүр Түрээслэгчийн МУХБ дахь 3600001547 дансанд тогтмол шилжүүлэхийг УБДС-аас шаардах;

6.1.7.Дулаан нийлүүлэх гэрээнд заасны дагуу Энергийн тарифаар тогтоосон дулааны үнийг үйлдвэрлэсэн дулааны хэмжээгээр төлбөр шилжүүлэхийг УБДС-аас шаардах;

6.1.8.Горимын дагуу Түрээслэгчийн дулаан үйлдвэрлэлийн хэмжээг эргэн төлөлтийн хугацаанд бууруулахгүй байхыг ДҮТ-өөс шаардах;

6.1.9.Тарифын дагуу Түрээслэгчийн дулаан нийлүүлэх үнэ, хэмжээг эргэн төлөлтийн хугацаанд бууруулахгүй, багасгахгүй байхыг ЭХЗХ-оос шаардах;

6.1.10.Түрээслүүлэгч, ЭХЗХ, ДҮТ, УБДС нар Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалсан өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах зэрэг



Түрээслэгч

ЭХЗХ

УБДС

ДҮТ

6.2. Түрээслэгч нь дараах үүрэгтэй:

6.2.1. Санхүүгийн түрээсийн төлбөрийг Хавсралт 2-д заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх, түүнчлэн өөрийн үйл ажиллагааны бусад зардлыг гаргахаас өмнө тэргүүн ээлжинд Гэрээний эргэн төлөлтийг хугацаанд гүйцэтгэж байх;

6.2.2. Санхүүгийн түрээсийн олголт хийсэн өдрөөс эхлэн олголт хийсэн дүнгээс Гэрээний 3.2-т заасан хэмжээгээр түрээсийн хүү тооцож, үндсэн төлбөрийн хамт МУХБ дахь өөрийн 3600001547 тоот харилцах данснаас Түрээслүүлэгчийн МУХБ дахь 3600005414 тоот дансанд шилжүүлэх хэлбэрээр төлөх;

6.2.3. Түрээсийн зүйлийн эвдрэл гэмтлийн эрсдэлийг бүрэн хүлээх;

6.2.4. Санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх, Гэрээ байгуулахтай холбоотойгоор гарах гаалийн татвар болон хураамж, мэдүүлгийн үнэ, мэдүүлэг бүрдүүлэлтийн зардал, НӨАТ-ын зардал, дотоод тээвэрлэлт, ачилт, буулгалт, угсралт, суурилуулалт, туршилт, нотариат, бүх төрлийн лавлагаа авах зардал, Түрээсийн зүйлийн ажил гүйцэтгэлтэй холбоотой гарах валютын зөрүү болон бусад холбогдох зардал, төлбөр, татвар, хураамж, шимтгэл, хохирол, торгуулийг Түрээслүүлэгчийн шаардсаны дагуу төлөх;

6.2.5. Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээний нийт санхүүжилтийн үнийн дүнгээс хамгийн багадаа 15 хувийг төлж, тус гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах;

6.2.6. Эргэн төлөлтийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Түрээслэгч нь өөрийн цахилгааны төлбөрийн зардлыг багасгах, буруулах, хойшлуулах арга хэмжээ авч ажиллах бөгөөд эргэн төлөлтийн зөрчил үүсгэсэн тохиолдолд уг арга хэмжээг шууд, үл маргах журмаар хэрэгжүүлнэ;

6.2.7. Түрээслэгч нь банк, санхүүгийн байгууллагаас зээл, түүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ авах, бусад этгээдэд өглөг, өр төлбөр үүсгэх, бусдын өмнө үүрэг хүлээхээр гэрээ, хэлцэл байгуулахаас өмнө Түрээслүүлэгчид тухай бүр мэдэгдэж, тэдгээрийн төлөлтийн хуваарийг түрээсийн төлбөрийн хуваарьтай давхцуулахгүй байх, эдгээр үйл ажиллагаанд Дулаан борлуулах гэрээг барьцаалахгүй буюу үүргийн гүйцэтгэл хангуулах хэрэгсэл болгохгүй байх;

6.2.8. Түрээсийн зүйлийг зориулалтаар нь ашиглах;

6.2.9. Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр түрээсийн зүйлийн өнгө, эд ангийг солихгүй, хийц, загвар, зориулалтыг өөрчлөхгүй байх;

6.2.10. Түрээсийн зүйлийн эд ангид хүнд эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд 48 /дөчин найм/ цагийн дотор Түрээслүүлэгчид мэдэгдэх. /Үүнд: утсан холбоо, цахим хэлбэрээр болон албан бичиг./


6.2.11. Түрээсийн зүйлийн бүрэн, бүтэн байдал, аливаа эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор урсгал засвар, үйлчилгээг хийх;

6.2.12. Түрээсийн зүйлийг хүлээн авах, тээвэрлэх, суурилуулах, ашиглалтад оруулах, турших, техникийн үйлчилгээ, засвартай холбогдон гарах зардал, Түрээслэгчид шилжүүлэхтэй холбогдон гарах зардал болон бусад зардлыг Гэрээ дуусгавар болох, Гэрээний хугацаа дуусах хүртэл хариуцах;

6.2.13. Түрээсийн зүйлийг зориулалтын дагуу ашиглаж, хэвийн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих, түүнд холбогдуулж түрээсийн зүйл байгаа газар болон үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй газруудад саадгүйгээр нэвтрэх зөвшөөрлийг Түрээслүүлэгчид олгох;

6.2.14. Түрээсийн зүйлийн хэвийн бус элэгдэл, эвдрэл гэмтэл, сервис үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйгээс үүссэн зөрчлийг арилгах;

6.2.15. Түрээсийн зүйл болон барьцаа хөрөнгөд аливаа засвар хийх, эд хөрөнгийн даатгалд даатгуулах болон түрээсийн зүйлийг шилжүүлэхтэй холбогдох зардал болон бусад зардлыг төлөх;



Түрээслэгч

ЭХЗХЧ

УБДС

ДҮТ

6.2.16. Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс Түрээслүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөх;

6.2.17. Хууль болон Гэрээнд заасан үндэслэлээр Түрээслүүлэгчээс түрээсийн зүйлийг түр буцаан авах буюу битүүмжлэх, гэрээг цуцлах арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд Түрээслүүлэгчээс гарсан холбогдох зардлыг нөхөн төлөх;

6.2.18. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол Гэрээний үүргийн биелэлтийг хуульд заасан журмаар бүрэн хангах;

6.2.19. Түрээсийн зүйлийн баталгаат хугацаанд түрээсийн зүйлийг нийлүүлэгчийн буруутай бус шалтгаанаар гарсан эвдрэл болон өөрийн санаатай болон болгоомжгүй хийсэн үйлдлийн улмаас гарах үр дагаврыг бүрэн хариуцах;

6.2.20. Түрээсийн зүйлд биет байдлын болон эрхийн доголдол илэрсэн, эсхүл гэнэтийн нөхцөл байдал бий болсноор эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах шаардлага гарсан бол энэ тухай Түрээслүүлэгчид мэдэгдэх;

6.2.21. Түрээслэгч нь Гэрээний эргэн төлөлтийн хуваарьт аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлт илэрхийлэх тохиолдолд Гэрээний Хавсралт 2-т заагдсан эргэн төлөлт хийгдэх хуваарьт өдрөөс хуанлийн 14 /арван дөрөв/-өөс доошгүй хоногийн өмнө Түрээслүүлэгчид бичгээр мэдэгдэж, шийдвэрлүүлэх;

6.2.22. Түрээслэгч нь Гэрээний хугацаанд санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үнэн зөвөөр тайлагнах;

6.2.23. Гэрээний хугацаанд Түрээслэгчийн аудитлагдсан санхүүгийн тайлан, тоног төхөөрөмжийн ашиглалтын дэлгэрэнгүй тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөө /бизнес төлөвлөгөө/, төсөв болон бусад холбоотой аливаа мэдээллийг Түрээслүүлэгчээс шаардсан тухай бүрд шуурхай гаргаж өгөх;

6.2.24. Түрээслэгч өөрийн байгууллагыг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулах, хувь эзэмшигчдийн бүтэц, эзэмшиж буй хувьд өөрчлөлт орох, татан буугдах, эрх зүйн байдлаа өөрчлөх, нэрээ солих, оршин байгаа газраа өөрчлөх, эсхүл эдгээр нөхцөл байдал бий болж болзошгүй тохиолдолд уг асуудлыг 30 /гуч/-аас доошгүй хоногийн өмнө Түрээслүүлэгчид албан бичгээр мэдэгдэх;

6.2.25. ЭХЗХ, ДҮТ, УБДС-д Төслийн хэрэгжилт болон Гэрээний эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг шаардсаны дагуу гарган өгөх;


6.2.26. Түрээслүүлэгчийн санаачилгаар Түрээслэгчийн санхүүгийн тайлан, балансад аудитын шалгалт гүйцэтгүүлж болох бөгөөд Аудитын шалгалт гүйцэтгэх байгууллагын талууд харилцан тохиролцон сонгож, холбогдох зардлыг Түрээслэгч тал хариуцах;

6.2.27. Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөр болон алданги, хохирлыг Түрээслүүлэгчийн шаардсаны дагуу Түрээслэгч нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө болон бусад үйл ажиллагааны орлогоор төлж барагдуулах;

6.2.28. Гэрээний 4.1-т заасан Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээний дагуу нийлүүлэгчийн хүлээсэн үүрэгт хяналт тавих, үүргээ биелүүлэхийг шаардах, нийлүүлэгч үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд Түрээслүүлэгчийн өмнө энэхүү Гэрээ болон Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээний дагуу хариуцлага хүлээж хохирлыг бүрэн барагдуулах;

6.2.29. Батлагдсан Горим, Тарифын дагуу Гэрээний эргэн төлөлтөө төлж барагдуулах боломжгүй нөхцөлд хүрсэн, эсхүл ЭХЗХ, ДҮТ, УБДС талууд Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалж Гэрээний эргэн төлөлтийн зөрчил үүсгэсэн тохиолдолд уг асуудлыг нэн даруй Түрээслүүлэгчид бичгээр мэдэгдэх;

6.2.30. ЭХЗХ-оос баталсан Тариф, ДҮТ-өөс батлуулсан Горимыг энэхүү Гэрээний эргэн төлөлтийг хангахаар Түрээслэгчид холбогдох дулааны хэмжээ, тарифыг ихэсгэх хэлбэрээр шинэчлэн батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд холбогдох мэдээлэл, баримт бичгийг ЭХЗХ, ДҮТ-д нэн даруй гаргаж өгөх;



Түрээслэгч

[Handwritten signature]

ЭХЗХ

[Handwritten signature]

УБДС

[Handwritten signature]

ДҮТ

[Handwritten signature]

6.2.31. Тариф, Горимыг ихэсгэх хэлбэрээр шинэчлэн, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан тохиолдолд тухайн тариф, горимын дагуу Түрээслэгч нь УБДС-тэй байгуулсан Дулаан нийлүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулж, гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг нэн даруй Түрээслүүлэгчид ирүүлэх;

6.2.32. Түрээслэгч нь энэхүү Гэрээнд зааснаас бусад шалтгаант нөхцөлөөр Дулаан нийлүүлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй байх, шинэчлэн байгуулахгүй байх, эсхүл тус гэрээг цуцлах, татгалзах, дуусгавар болгох аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй;

6.2.33. УБДС нь дулааны төлбөрийг Түрээслэгчийн МУХБ дахь 3600001547 тоот дансанд шилжүүлээгүй, хугацаа хэтрүүлсэн, бүрэн шилжүүлээгүй зэрэг Түрээслэгчийн Гэрээний эргэн төлөлтийг хангах нөхцөл боломжийг бүрдүүлээгүй аливаа зөрчлийг УБДС нь санаатай болон болгоомжгүй байдлаар гаргасан тохиолдолд Түрээслэгч нь уг зөрчлийг арилгуулах шуурхай арга хэмжээ авах;

6.2.34. Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийг төлөх хуваарьт хугацаа болохоос өмнө МУХБ дахь өөрийн 3600001547 тоот дансанд эргэн төлөлт хийх мөнгөн дүнгийн хэмжээгээр үлдэгдэлтэй байлгах;

6.2.35. Төслийн хэрэгжилт, Горим, Тариф, Дулаан нийлүүлэх гэрээ, Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээнд холбогдох бүхий л мэдээлэл, баримт бичгийг Түрээслүүлэгчээс шаардсан тохиолдолд нэн даруй гаргаж өгөх үүрэгтэй;

6.2.36. Даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр авсан тохиолдолд авсан нөхөн төлбөрийн хувь тэнцүү хэмжээгээр даатгалын хураамжийг нөхөн төлөх;

6.2.37. Түрээсийн зүйлийг зориулалтын дагуу ашиглаж, хэвийн ажиллаж байгаа эсэхэд Түрээслүүлэгчээс тогтмол хяналт тавих, битүүмжлэх, түүнд холбогдуулж түрээсийн зүйл байгаа газар болон Түрээслэгчийн үйл ажиллагаа хэрэгжүүлж буй газруудад нэвтрэхэд саадгүйгээр оруулах;

6.2.38. Холбогдох хууль тогтоомж, гэрээ, шийдвэрт заасан бусад үүрэг.

ЗӨВШӨӨРСӨН:



“АМГАЛАН ДУЛААНЫ
СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.МӨНХӨӨ

Долоо.ЭХЗХ-ны эрх, үүрэг

7.1. ЭХЗХ нь дараах эрхтэй:

7.1.1. ЭХЗХ нь өөрийн баталсан Тарифаа ихэсгэх хэлбэрээр шинэчлэн батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага бий болсон тохиолдолд Түрээслүүлэгчээс Гэрээний эргэн төлөлтийн тооцооллыг гаргуулан авах;


7.1.2. ЭХЗХ нь өөрийн баталсан Тарифаа ихэсгэх хэлбэрээр дахин батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тохиолдолд Түрээслэгчээс гэрээ, хууль тогтоомж, журамд заасны дагуу холбогдох баримт бичгийг гаргуулан авах;

7.1.3. Төслийн хэрэгжилт болон Гэрээний эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг Түрээслэгчээс гаргуулан авах.

7.2. ЭХЗХ нь дараах үүрэгтэй:

7.2.1. ЭХЗХ нь өөрийн баталсан Тарифыг багасгах, бууруулах хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулахгүй, шинэчлэн батлахгүй, цуцлахгүй, мөн хүчингүйд тооцохгүй байх;

7.2.2. Түрээслэгчийн Гэрээний эргэн төлөлт хийхэд шаардлагатай нөхцөл байдлыг бүрдүүлж, Гэрээний эргэн төлөлт хийж дуусгах хүртэлх хугацаанд Гэрээний 2.1.2-т заасан хамгийн багадаа 30%-иас багагүйгээр байхаар баталсан Тарифыг бууруулахгүйгээр, Гэрээний эргэн төлөлтийг бүрэн хангах хэмжээгээр ихэсгэх, нэмэгдүүлэх;



Түрээслэгч

ЭХЗХ

УБДС

ДҮТ

7.2.3. Түрээслэгч Гэрээний эргэн төлөлтөө төлж чадахгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Индексжүүлэлтийн дагуу Тарифаа ихэсгэх хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах;

7.2.4. Хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд Түрээслэгчид холбогдох дүрэм, журам, заавар, аргачлал баталж мөрдүүлэх;

7.2.5. Гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомж, гэрээ, шийдвэрт заасан үүргээ биелүүлээгүй, түүнчлэн Тарифыг Гэрээнд зааснаас бусад нөхцөлөөр бууруулж, багасгах хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулсан, шинэчлэн баталсан, эсхүл цуцалсан, хүчингүйд тооцсоноос шалтгаалж Түрээслэгч нь Гэрээний эргэн төлөлтийн зөрчил үүсгэсэн тохиолдолд Түрээслүүлэгч болон Түрээслэгчид учирсан хохирол, Түрээслэгчийн төлөх хуримтлагдсан алдангийг тус тус төлж барагдуулах;

7.2.6. Түрээслэгчийн дулааны эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг бага түвшинд тогтоох аргачлалыг батлах, тооцоог хянах;

7.2.7. Түрээслэгчийн үйл ажиллагаанд холбогдох мэдээлэл болон бусад баримт бичиг, мэдээллийг шаардсан хугацаанд Түрээслүүлэгчид гаргаж өгөх;



7.2.8. Тарифын дагуу Түрээслэгч нь Гэрээний эргэн төлөлтийг хангах боломжгүй болсон тохиолдолд Тарифыг бууруулж багасгахгүйгээр хамгийн багадаа 30%-аас багагүйгээр, Гэрээний эргэн төлөлтийг бүрэн хангах хэмжээгээр ихэсгэх байдлаар шинэчлэн, эсхүл нэмэлт өөрчлөлт оруулж батлах;

7.2.9. Тарифын дагуу Түрээслэгч нь Гэрээний эргэн төлөлтийг хангах боломжгүй болсон тохиолдолд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах.

7.2.10. Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээний нийт санхүүжилтийн үнийн дүнгээс хамгийн багадаа 15 /арван тав/ хувийг Түрээслэгчээс төлөхтэй холбоотойгоор Тарифын зохицуулалт хийх;

7.2.11. Холбогдох хууль тогтоомж, гэрээ, шийдвэрт заасан бусад үүрэг.

ЗӨВШӨӨРСӨН:



 “ЭРЧИМ ХҮЧНИЙ
 ЗОХИЦУУЛАХ ХОРОО”-
 НЫ ДАРГА
 Э.ТҮВШИНЧУЛУУН

Найм.ДҮТ-ийн эрх, үүрэг

8.1. ДҮТ нь дараах эрхтэй. Үүнд:

8.1.1. Түрээслэгчийн үйлдвэрлэх дулааны хэмжээг ихэсгэх, хугацааг нь сунгахтай холбоотойгоор дахин горим батлуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд Түрээслүүлэгчээс Гэрээний эргэн төлөлтийн тооцооллыг гаргуулан авах;

8.1.2. ДҮТ нь Түрээслэгчийн үйлдвэрлэх дулааны хэмжээг ихэсгэхтэй холбоотойгоор дахин горим батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд Түрээслэгчээс гэрээ, хууль тогтоомж болон холбогдох журамд заасны дагуу баримт бичиг, мэдээллийг гаргуулан авах;

8.1.3. Төслийн хэрэгжилт болон Гэрээний эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг Түрээслэгчээс гаргуулан авах.

8.2. ДҮТ нь дараах үүрэгтэй. Үүнд:


8.2.1. Түрээслэгчийн эрчим хүчний үйлдвэрлэлийн хэрэглээг тэнцвэржүүлэх горимын зохицуулалтыг хийж, нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн системийн тасралтгүй, найдвартай, тогтвортой ажиллагааг хангаж ажиллах;


8.2.2. Горимын дагуу Түрээслэгчийн дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээг эргэн төлөлт бүрэн хангагдах хүртэлх хугацаанд бууруулах, багасгах хэлбэрээр цуцлуулахгүй, мөн хүчингүйд тооцуулахгүй байх;

ДУ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК
 Түрээслүүлэгч
ХУУЛЬЧ

Түрээслэгч


ЭХЭЖ


УБДС


ДҮТ


8.2.3. Гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомж, гэрээ, шийдвэрт заасан үүргээ биелүүлээгүй, түүнчлэн Горимыг Гэрээнд зааснаас бусад нөхцөлөөр бууруулж, багасгах хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулсан, шинэчлэн баталсан, эсхүл цуцалсан, хүчингүйд тооцсоноос шалтгаалж Түрээслэгч нь Гэрээний эргэн төлөлтийн зөрчил үүсгэсэн тохиолдолд Түрээслүүлэгч болон Түрээслэгчид учирсан хохирол болон Түрээслэгчийн төлөх хуримтлагдсан алдангийг тус тус төлж барагдуулах бөгөөд Түрээслэгчийн Гэрээний төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар үл маргах журмаар төлбөрийн үүрэг хүлээнэ;

8.2.4. Түрээслэгч нь эргэн төлөлтөө төлж чадахгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Горимд холбогдох Түрээслэгчийн үйлдвэрлэх дулааны эрчим хүчний хэмжээг бууруулахгүйгээр, Гэрээний эргэн төлөлтийг бүрэн хангах хэмжээнд ихэсгэж батлуулах;

8.2.5. Дамжуулах сүлжээний хүрээнд хийгдэж байгаа дулааны эрчим хүчний хязгаарлалтын талаар тухай бүр Түрээслүүлэгчид мэдээлэх;

8.2.6. Түрээслэгчийн үйл ажиллагаанд холбогдох мэдээлэл болон бусад баримт бичиг, мэдээллийг шаардсан хугацаанд Түрээслүүлэгчид гаргаж өгөх;

8.2.7. Түрээслэгчийн Гэрээний эргэн төлөлтийг төлөх чадварт нь нөлөөлөх эрсдэл үүссэн, эсхүл үүсэх нөхцөл байдал бий гэж үзсэн тохиолдолд уг асуудлыг Түрээслүүлэгчид нэн даруй мэдэгдэх;

8.2.8. Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээний нийт санхүүжилтийн үнийн дүнгээс хамгийн багадаа 15 /арван тав/ хувийг Түрээслэгчээс төлөхтэй холбоотойгоор Горимын зохицуулалт хийх, эсхүл үл маргах журмаар төлбөрийг шууд гүйцэтгэх;

8.2.9. Холбогдох хууль тогтоомж, гэрээ, шийдвэрт заасан бусад үүрэг.

ЗӨВШӨӨРСӨН:

[Handwritten signature]



Ес.УБДС-ийн эрх, үүрэг

9.1. УБДС нь дараах эрхтэй. Үүнд:

9.1.1. Төслийн хэрэгжилт болон эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг Түрээслэгчээс гаргуулан авах;

9.1.2. ЭХЗХ болон ДҮТ-өөс баталсан Горим, Тарифын хэмжээг ихэсгэхтэй холбоотойгоор шийдвэр гаргасан тохиолдолд Түрээслэгчээс холбогдох мэдээлэл, баримт бичгийг гаргуулан авах.


9.2. УБДС нь дараах үүрэгтэй. Үүнд:

9.2.1. УБДС нь Түрээслэгчтэй Дулаан нийлүүлэх гэрээний дагуу дулаан худалдаж авах төлбөр тооцоог Гэрээний эргэн төлөлт бүрэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд Чадлын тарифаар тогтоосон дулааны төлбөрийг ямар ч тохиолдолд тогтмол, сар бүр, Энергийн тарифаар тогтоосон дулааны төлбөрийг үйлдвэрлэсэн дулааны хэмжээгээр тухай бүр саадгүй, шуурхай байдлаар зөвхөн Түрээслэгчийн МУХБ дахь 3600001547 тоот харилцах дансанд шилжүүлэх;

9.2.2. Гэрээнд заасан эргэн төлөлтийн хугацааны дагуу Түрээслэгчийн төлбөр төлөх хуваариас өмнө Дулааны төлбөрийг Түрээслэгчид шилжүүлэх, эргэн төлөлтийг хангуулах;

9.2.3. Түрээслэгчийн үйл ажиллагаанд холбогдох мэдээлэл болон бусад баримт бичиг, мэдээллийг шаардсан хугацаанд Түрээслүүлэгчид гаргаж өгөх;

9.2.4. Түрээслэгчийн Гэрээний эргэн төлөлтийг төлөх чадварт нь нөлөөлөх эрсдэл үүссэн, эсхүл үүсэх нөхцөл байдал бий гэж үзсэн тохиолдолд уг асуудлыг Түрээслүүлэгчид нэн даруй мэдэгдэх;



Түрээслэгч

[Handwritten signature]

ЭХЗХ

[Handwritten signature]

УБДС

[Handwritten signature]

ДҮТ

[Handwritten signature]

9.2.5. Гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомж, Дулаан нийлүүлэх гэрээ, шийдвэрт заасан үүргээ биелүүлээгүй, Түрээслэгчид шилжүүлэх дулааны төлбөрийг зөвхөн Түрээслэгчийн МУХБ дахь 3600001547 тоот харилцах дансанд шилжүүлээгүй, өөр дансанд шилжүүлсэн, түүнчлэн Дулаан нийлүүлэх гэрээг Гэрээнд зааснаас бусад нөхцөлөөр нэмэлт, өөрчлөлт оруулсан, шинэчлэн баталсан, эсхүл цуцалсан, татгалзсан, хүчингүйд тооцсоноос шалтгаалж Түрээслэгч нь Гэрээний эргэн төлөлтийн зөрчил үүсгэсэн тохиолдолд Түрээслүүлэгч, Түрээслэгчид учирсан хохирол болон Түрээслэгчийн төлөх хуримтлагдсан алдангийг тус тус төлж барагдуулах;

9.2.6. ЭХЗХ, ДҮТ-өөс Гэрээнд зааснаар Горим, Тарифыг ихэсгэх хэлбэрээр шинэчлэн баталсан тохиолдолд тухайн шийдвэрийн дагуу Түрээслэгчтэй байгуулсан Дулаан нийлүүлэх гэрээг шинэчлэн байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

9.2.7. Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор Дулааны төлбөрийг бусад эрчим хүчний үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагаас онцгойлж, тэргүүн ээлжинд Түрээслэгчийн МУХБ дахь 3600001547 тоот харилцах дансанд шилжүүлэх;

9.2.8. Холбогдох хууль тогтоомж, гэрээ, шийдвэрт заасан бусад үүрэг.

ЗӨВШӨӨРСӨН:



Арав Даатгал

“УЛААНБААТАР
ДУЛААНЫ СҮЛЖЭЭ”
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Г.БАЯРСАЙХАН

10.1. Түрээсийн зүйлийг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор заавал даатгуулна.

10.2. Санхүүгийн түрээсийн гэрээний хугацаанд түрээсийн зүйл нь даатгагдсан байна.

10.3. Даатгалын гэрээ нь хамгийн багадаа 1 /нэг/ жилийн хугацаатай байх ба тухайн хугацааны даатгалын хураамж бүрэн төлөгдсөн байна. Шаардлагатай тохиолдолд даатгалын хураамжийг хэсэгчлэн төлж болно.

10.4. Түрээсийн зүйлийн даатгалын гэрээг байгуулахдаа энэхүү Гэрээний 4.1-д заасан Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээнд тусгасан үнийн дүнгээр түрээсийн зүйлийн үнэлгээг тусгуулсан байна.

10.5. Түрээслүүлэгч нь даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Санхүүгийн түрээсийн гэрээний хавсралтад тусгаж, эсхүл даатгалын гэрээнд заасан хуваарийн дагуу Түрээслэгч талаар төлүүлнэ.


10.6. Даатгалын гэрээг байгуулахдаа гэрээнд даатгалын нөхөн олговор авах эрх бүхий этгээдээр Түрээслүүлэгч байх ба даатгалын тохиолдлоос үүссэн аливаа хохиролд даатгагчаас олгосон нөхөн олговрыг Түрээслүүлэгч хүлээн авна.

10.7. Даатгагчаас олгосон нөхөн олговрыг Түрээслүүлэгч тал Гэрээний 10.9-т заасан нөхцөл хангагдсан, мөн Түрээслүүлэгч талын эрх бүхий ажилтны хяналт, шалгалтын дүгнэлт зэргийг үндэслэн Түрээслэгч талд олгоно.

10.8. Даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгалын байгууллага, хууль, хүчний байгууллага, засвар үйлчилгээний байгууллагад хандах, харилцах зэрэгт Түрээслэгч нь гол төлөөлөх үүргийг хүлээнэ. Түрээслүүлэгч эдгээр асуудалд оролцох бүрэн эрхтэй.

10.9. Даатгалын байгууллагын нөхөн төлбөр төлөгдсөн эсэхээс үл хамааран түрээсийн зүйлд учирсан гэмтэл, доголдлыг хуанлийн 14 хоногт багтаан засварлах ба зардлыг Түрээслэгч тал хариуцна.

10.10. Түрээслэгч тал даатгалын байгууллагатай даатгалын нөхөн төлбөр төлөх эсэх асуудал дээр харилцан тохиролцохгүй байх нь Түрээслүүлэгч талд учирсан хохирлыг нөхөж барагдуулахгүй байх үндэслэл болохгүй.



Түрээслэгч

ЭХЗХ

УБДС

ДҮТ

10.11. Даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр авсан тохиолдолд авсан нөхөн төлбөрийн хувь тэнцүү хэмжээгээр даатгалын хураамжийг нөхөн төлөх;

Арван нэг. Түрээсийн төлбөр төлөлт

11.1. Түрээсийн төлбөрийг Гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх хугацаа нь Гэрээний 3.4-т заасан хугацаанаас хэтрэхгүй байна.

11.2. Түрээслэгч нь түрээсийн төлбөрийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу хуваарьт хугацаанд нь төлөөгүй тохиолдолд зөрчил үүссэн дүнгээс Гэрээний 3.8-д заасан хувиар төлбөрийн зөрчлийг арилгах хүртэл хугацаанд тооцсон алдангийг төлнө.

11.3. ЭХЗХ, ДҮТ, УБДС нар Түрээслэгчийн эргэн төлөлтийн зөрчилд буруутай үйлдэл эс үйлдэхүй гаргасан тохиолдолд Түрээслүүлэгч, Түрээслэгчид учирсан хохирол болон Түрээслэгчийн төлөх Гэрээний 11.2-т заасан алдангийг тус тус төлнө.

11.4. Түрээсийн төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд санхүүгийн түрээсийн төлбөрийг даатгалын хураамж, алданги, түрээсийн хүүгийн төлбөр, үндсэн төлбөр гэсэн дарааллаар төлнө.

11.5. Түрээслэгч нь Санхүүгийн түрээсийн төлбөрийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанаас өмнө үндсэн төлбөр, түрээсийн хүүгийн төлбөрийг төлж болно.

11.6. Гэрээний хугацаа дууссан нь гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй Түрээслэгчийг үндсэн төлбөр, түрээсийн хүүгийн төлбөр, алданги, даатгалын хураамжийг төлөхгүй байх үндэслэл болохгүй.

11.7. Түрээслүүлэгч болон Түрээслэгч харилцан тохиролцсоноор түрээсийн зүйл нь үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж байхаас үл хамааран Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу Түрээслэгч тал төлөх үүрэг хүлээнэ.

11.8. Түрээсийн зүйлээр эцсийн бүтээгдэхүүн боловсруулж, үйлдвэрийг бүрэн ажиллагаанд оруулах хугацаа нь 4.1-д заасан Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээний хугацаанаас илүүгүй байх бөгөөд тус хугацаанд үйлдвэрийг бүрэн ажиллагаанд оруулаагүй үйлдэл эс үйлдэл нь Гэрээний Хавсралт 2-т заасны дагуу түрээсийн төлбөрийг хугацаанд төлөхгүй байх үндэслэл болохгүй.

11.9. Түрээслэгч нь Гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлбөр хийх өдөр болмогц үндсэн төлбөр, түрээсийн хүүгийн төлбөр, алданги, даатгалын хураамжийг зөвхөн Түрээслүүлэгчийн МУХБ дахь 3600001454 тоот харилцах дансанд шилжүүлнэ.

11.10. Түрээслэгчийн МУХБ дахь 3600001547 тоот харилцах данснаас Түрээслүүлэгчийн МУХБ-н дахь 3600001454 тоот харилцах дансанд Гэрээний эргэн төлөлтийг төлөх төлбөр тооцооны асуудал нь Гэрээний 2.1.11-д заасан Төлбөр тооцооны хамтран ажиллах гэрээгээр зохицуулагдана.

11.11. Түрээсийн зүйлийг ашиглаж байгаа эсхээс үл хамааран түрээсийн төлбөрийг Гэрээний Хавсралт 2-д заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлнө.

11.12. Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарьт хугацаа нь амралтын болон нийтээр амрах баярын өдөр байх тохиолдолд өмнөх ажлын өдөр төлбөрийг Түрээслэгч тал шилжүүлнэ.

11.13. Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарьт хугацаанд төлөх төлбөр нь Түрээслүүлэгчийн дансанд орж ирсэн өдрөөр төлбөрийн үүрэг хангагдсан гэж үзнэ.


ЗӨВШӨӨРСӨН:



“АМГАЛАН ДУЛААНЫ
СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
M.МӨНХӨӨ

Арван хоёр. Гэрээний хариуцлага

12.1. Түрээслүүлэгч урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр Түрээсийн зүйл болон Түрээслэгчийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй зуух, нүүрс хадгалах агуулах, нүүрс тэжээгч, нүүрсний



Түрээслэгч
[Signature]

ЭХЗХ
[Signature]

УБДС
[Signature]

ДҮТ
[Signature]

бутлуур зэрэг Түрээсийн зүйлээс бусад үйлдвэрийн тоног төхөөрөмжийг дараах тохиолдолд битүүмжилнэ.

12.1.1. Түрээслэгч түрээсийн зүйлийг Түрээслүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусад шилжүүлсэн;

12.1.2. Түрээслэгч түрээсийн төлбөрийг гурван удаа дараалан төлөөгүй;

12.1.3. Түрээслэгч түрээсийн зүйлийг гэрээнд зааснаас өөр зориулалтаар ашигласан;

12.1.4. Түрээслэгч түрээсийн зүйлийн ашиглалт, засвар, үйлчилгээтэй танилцах боломжийг Түрээслүүлэгчид олгоогүй;

12.1.5. Түрээслэгч Гэрээний үүргийн гүйцэтгэлийг Түрээслүүлэгч талын олгосон хугацаанд биелүүлээгүй зэрэг болно.

12.2. Түрээслүүлэгч нь Гэрээний үүргийн зөрчил арилмагц түрээсийн зүйлийг Түрээслэгчид буцаан өгч, Түрээслэгч нь Гэрээнд заасан эрх, үүргээ үргэлжлүүлэн биелүүлэх үүрэгтэй.

12.3. ЭХЗХ, ДҮТ, УБДС нар нь үүргээ биелүүлээгүйгээс Түрээслэгч нь төлбөрийн зөрчил үүсгэвэл үүссэн алданги болон Түрээслүүлэгч, Түрээслэгчид учирсан хохирлыг буруутай этгээд нь хариуцаж барагдуулна.

12.4. Түрээслэгч нь гэрээнд заасан хугацаа, хуваарийн дагуу үндсэн төлбөр, түүний хүү, алдангийг төлөөгүй, мөн Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Түрээслүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг ЭХЗХ, ДҮТ, УБДС болон Түрээслэгчээс албан бичгээр шаардана.

12.5. Гэрээний 12.4-т заасан албан бичигт дурдсан хугацаанд ЭХЗХ, ДҮТ, УБДС болон Түрээслэгч нь үүргээ биелүүлээгүй бол ирүүлсэн албан хүсэлтийн дагуу Түрээслүүлэгчээс хуанлийн 14 /арван дөрөв/ хүртэлх хоногийн нэмэлт хугацаа тогтоож болно.

12.6. Үүргийн гүйцэтгэл хангуулах тухай Түрээслүүлэгчийн албан мэдэгдэлд хуанлийн 30 /гуч/ хоногийн дотор ЭХЗХ, ДҮТ, УБДС болон Түрээслэгч нь хариу өгөөгүй эсхүл мэдэгдэлд дурдсан төлбөрийн шаардлага, болон бусад холбогдох үүргийн гүйцэтгэлийг бүрэн хэмжээгээр буюу зохих ёсоор биелүүлээгүй бол Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах үндэслэл болно.


12.7. Гэрээний үүргийн гүйцэтгэлийн зөрчлийн улмаас шүүхийн байгууллагаар хэрэг хянан шийдвэрлүүлэх ажиллагааны явцад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар Түрээслүүлэгч талаас хүсэлт гаргасан тохиолдолд Талуудаас уг ажиллагааг үл маргах журмаар хүлээн зөвшөөрч, шүүхийн шийдвэр, захирамж гаргуулахад аливаа няцаасан хариу тайлбар гаргахгүй байх үүргийг Түрээслүүлэгчээс бусад тал хүлээнэ.

12.8. Түрээслэгч нь түрээсийн төлбөрийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу хуваарьт хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Гэрээний 3.8-д заасан алдангийг төлбөрийн зөрчлийг арилгах хүртэл хугацаанд тооцон төлөх бөгөөд уг эргэн төлөлтийг зөрчилд ЭХЗХ, ДҮТ, УБДС нар буруутай бол алдангийн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлнэ.

12.9. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг гэм буруутай тал нь нөгөө талд төлөх үүрэгтэй.

12.10. Түрээслэгчийн Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх төлбөрийн үүрэгт хугацаа хэтэрсэн зөрчил үүссэн, эсхүл цаашид төлбөрийн үүргийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ДҮТ-өөс уг төлбөрийн үүргийг бүрэн хариуцаж, үл маргах журмаар төлөх үүргийг хүлээнэ.

12.11. Түрээсийн зүйлийг хүлээн авснаас хойш Түрээслүүлэгчийн зөвшөөрөлгүй түүний үндсэн хийц, зориулалт, зохион байгуулалтыг өөрчилсөн, гэрээнд зааснаас өөр зориулалтаар ашигласан, эвдсэн, гэмтээсэн, алдсан үрэгдүүлснээс үүсэх аливаа хохирлыг Түрээслэгч хариуцна.



Түрээслэгч

ЭХЗХ

УБДС

ДҮТ

Арван гурав. Гэрээ дуусгавар болох

13.1. Гэрээний төлбөрийн үүрэг бүрэн хангагдсан тохиолдолд Гэрээ дуусгавар болох бөгөөд түрээсийн зүйлийг Түрээслэгчийн өмчлөлд шилжүүлнэ.

13.2. Түрээсийн зүйлийг өмчлөлд шилжүүлэхэд шаардлагатай баримт бичгийг Түрээслүүлэгчээс Түрээслэгчид хүлээлгэн өгөх ба хүлээлгэн өгсөн өдрөөс ажлын 5 /тав/ хоногт багтаан Түрээслэгч нь түрээсийн зүйлийн өөрийн өмчлөлд шилжүүлэн авах үүрэгтэй.

13.3. Түрээслэгч нь түрээсийн төлбөрийг гурван удаа дараалан төлөөгүй бөгөөд Түрээслүүлэгчийн тогтоосон хугацаанд төлбөрийн зөрчлийг шаардлагын дагуу буюу зохих ёсоор бүрэн барагдуулаагүй тохиолдолд Түрээслүүлэгчийн санаачилгаар Гэрээг хугацаанаас нь өмнө цуцална.

13.4. ЭХЗХ, ДҮТ, УБДС нар нь үүргээ биелүүлээгүйгээс Гэрээний 13.3-т заасан нөхцөл байдал үүссэн, эсхүл Гэрээнд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд Түрээслүүлэгчийн санаачлагаар Гэрээг хугацаанаас нь өмнө мөн адил цуцална.

13.5. Түрээслүүлэгч дараах нөхцөл үүссэн тохиолдолд өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй. Үүнд:

13.5.1. Түрээслэгчийн санхүүгийн түрээсийн хүсэлт гаргах болон түрээсийн шийдвэрийн гаргалтын явцад ирүүлсэн баримт, материал нь хуурамчаар үйлдэгдсэн гэдэг нь тогтоогдох, эсвэл Түрээслэгчийн хэвийн үйл ажиллагаа болон эрх зүйн чадамж алдагдсан нөхцөлд;

13.5.2. ЭХЗХ, ДҮТ, УБДС нар Гэрээний үүргийг зөрчсөн тохиолдолд;

13.5.3. Түрээслэгч нь Гэрээний үүргээ 2 ба түүнээс дээш удаа биелүүлээгүй;

13.5.4. Түрээсийн зүйлийн урьдчилгаа төлбөрийг зохих хугацаанд төлөөгүй тохиолдолд;

13.5.5. Түрээсийн төлбөр гурван удаа төлөөгүй ба Түрээслүүлэгчээс хүргүүлсэн хуанлийн 14 /арван дөрөв/ хоногийн хугацаатай мэдэгдлийн хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаагүй тохиолдолд;

13.5.6. Түрээслэгчид баталгаа, батлан даалт гаргасан этгээд болон ЭХЗХ, ДҮТ, УБДС нар дампуурсан эсхүл бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсон тохиолдолд;

13.5.7. Түрээсийн зүйл нь цаашид ашиглах боломжгүй хүртэлх хэмжээнд гэмтсэн, сүйрсэн;

13.5.8. Түрээсийн зүйлийн даатгалыг Гэрээний 10 дугаар зүйлд зааснаар хийж гүйцэтгээгүй;

13.5.9. Түрээслэгч нь мөнгө угаах, терроризмын гэмт хэрэгт холбоотой гэдэг нь нотлогдсон;

13.5.10. Гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл Түрээслүүлэгчээс тавьсан шаардлагыг мэдэгдэл хүргүүлснээс хойш мэдэгдэлд заасан хугацаанд биелүүлээгүй.

13.6. Түрээслүүлэгч нь дараах тохиолдолд санхүүгийн түрээсийн олголт хийж дуусахаас өмнө Гэрээг цуцлах эрхтэй. Үүнд:

13.6.1. ЭХЗХ, УБДС, ДҮТ болон Түрээслэгч нар нь энэхүү Гэрээ болон бусад холбогдох гэрээ, хууль тогтоомж шийдвэрт заасан үүргээ биелүүлээгүй;


13.6.2. Түрээслэгч нь Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээнд заасан 15 /арван тав/ хувь хүртэлх санхүүжилт буюу төлбөрөө төлөөгүй;

13.6.3. Түрээслэгч нь Гэрээний Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй;

13.6.4. Түрээслэгчийн санхүүгийн байдалд их хэмжээний сөрөг өөрчлөлт орсон;

13.6.5. Түрээслэгч нь санхүүгийн түрээсийн үйлчилгээ авах зорилгоор хуурамч баримт, материал бүрдүүлсэн.

13.6.6. Түрээсийн зүйлийг нийлүүлэх гэрээнд заасан үүргээ Эрчим хүчний яам болон нийлүүлэгч буюу ажил гүйцэтгэгч тус тус биелүүлээгүй.



Түрээслэгч

ЭХЗХ

УБДС

ДҮТ

13.7. Гэрээний 13.6-т зааснаар Гэрээг цуцалсан тохиолдолд санхүүгийн түрээсийн олголт хийсэн нийт төлбөрийг Түрээслэгч, ДҮТ, ЭХЗХ, УБДС талаас Түрээслүүлэгчид бүрэн төлж барагдуулж, хохиролгүй болгох үүргийг хүлээнэ.

Арван дөрөв. Давагдашгүй хүчин зүйл

14.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал: газар хөдлөлт, үер, мөндөр, аянга, гал түймэр, байгалийн бусад аюулт үзэгдэл, дайны байдал үүссэн гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

Арван тав.Маргааныг шийдвэрлэх

15.1. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба эвийн журмаар маргааныг шийдвэрлэж боломжгүйд хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арван зургаа. Бусад зүйл

16.1. Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

16.2. Гэрээтэй холбоотой аливаа мэдэгдэл, албан бичгийг талууд Гэрээнд заасан хаягаар илгээнэ. Хаяг өөрчлөгдсөн тохиолдолд талууд, нөгөө талдаа мэдэгдэх үүрэгтэй.

16.3. Талууд харилцан тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлтийг оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь энэхүү гэрээний адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

16.4. Гэрээг 8 /найм/ эх хувь үйлдсэн бөгөөд хувиуд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна. Гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

<p>Түрээслүүлэгч талыг төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.Цэрлэдном ХХК Улаанбаатар хот 1117240335 61992333 ХХК Улаанбаатар хот</p>	<p>Түрээслэгч талыг төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.Мөнхөө ХХК Улаанбаатар хот 920030414 921646 ХХК Улаанбаатар хот</p>	<p>ЭХЗХ-г төлөөлж: "ЭХЗХ"-НЫ ДАРГА Э.Түвшинчулуун Унэ тарифын газрын дарга Улаанбаатар хот 5410523 ХХК Улаанбаатар хот</p>	<p>УБДС-г төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.Баярсайхан ХХК Улаанбаатар хот 26884799877 ХХК Улаанбаатар хот</p>	<p>ДҮТ-г төлөөлж: УЛААНБААТАР ХОТ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.Балжинням ХХК Улаанбаатар хот 902010314 ХХК Улаанбаатар хот</p>
<p>Ххлах Мэргэжилтэн /Н.Бадраг/</p>	<p>Ерөнхий инженер /Э.Мөнхжаргал/</p>	<p>Унэ тарифын газрын дарга /Б.Эрдэнэбулган/</p>	<p>Ерөнхий инженер /Д.Мөнхжаргал/</p>	<p>Ерөнхий инженер /Б.Баатар/</p>

Гэрээг хянасан:

Түрээслүүлэгчийн хуульч
2022 оны 10 дугаар сарын 28-ны /ний өдөр

ДИ БИ ЭМ ЛЭЗЭНГ ХХК
Хуульч
/Д.Номин/
Хуульч

ДИ БИ ЭМ ЛЭЗЭНГ ХХК
Түрээслүүлэгч
Хуульч

Түрээслэгч

ЭХЗХ

УБДС

ДҮТ

Handwritten signatures for Түрээслэгч, ЭХЗХ, УБДС, and ДҮТ.

2022 оны 10 дугаар 28-ны өдөр
байгуулсан СТГ-22/01 дугаартай
Санхүүгийн түрээсийн гэрээний
Хавсралт-1



САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ЗҮЙЛ

№	Түрээсийн зүйлийн нэр	Үйлдвэрлэгч	Үйлдвэрлэсэн огноо	Техникийн үзүүлэлтүүд	Тоо ширхэг	Дагалдах хэрэгсэл	Ашиглах зориулалт
1	Зуух	БНХАУ-ын Хунан индастриал экүйпмент инсталейшн” ХХК	2022-2023	116МВт	1 багц	Сүлжээ усны насос, деазратор, нүүрс тэжээгч, хими усны систем, цахилгаан тоноглол	Эрчим хүчний дулаан үйлдвэрлэх
2	Үнс хадгалах агуулах	БНХАУ-ын Хунан индастриал экүйпмент инсталейшн” ХХК	2022-2023	7000м ³	4ш	-	Үнс хадгалах


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Түрээслүүлэгч талыг төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.Цэрэнсодном
 Түрээслэгч талыг төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.Мөнхөө
 ЭХЗХ-г төлөөлж: “ЭХЗХ”-НЫ ДАРГА Э.Тувшинчулуун
 УБДС-г төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.Баярсайхан
 ДУТ-г төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.Балжинням

Ахлах мэргэжилтэн /Н.Бадвал/
 Ерөнхий инженер /Э.Мөнхжаргал/
 Үнэ тарифын газрын дарга /Б.Эрдэсбулган/
 Ерөнхий инженер /Ш.Мөнхжаргал/
 Ерөнхий инженер /Б.Баатар/

Санхүүгийн түрээсийн зүйлийн жагсаалтыг хянасан:
Санхүүгийн түрээсийн мэргэжилтэн

Э.Бат-Эрдэнэ Э.Бат-Эрдэнэ



Түрээслэгч *ЭХЗХ* УБДС ДУТ


2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр
байгуулсан СТФ-22/01 дугаартай
Санхүүгийн түрээсийн гэрээний
Хавсралт-2



САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

***Эргэн төлөлтийн хуваарьт төлбөрийн өдөр амралтын өдөр байгаа тохиолдолд түүний өмнөх ажлын өдөр төлбөрийг гүйцэтгэсэн байна.

Огноо	Олгосон	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Нийт төлбөр	Үлдэгдэл
12/5/2022	789,296,624	-	-	-	789,296,624
1/5/2023	42,371,141,777	-	7,709,157	7,709,157	43,160,438,401
2/5/2023	7,898,048,014	1,400,000,000	421,553,323	1,821,553,323	49,658,486,415
3/5/2023	-	1,800,000,000	438,083,086	2,238,083,086	47,858,486,415
4/5/2023	279,466,291	1,200,000,000	467,439,737	1,667,439,737	46,937,952,706
5/5/2023	1,111,436,035	1,500,000,000	443,660,101	1,943,660,101	46,549,388,741
6/5/2023	1,249,761,327	700,000,000	454,653,619	1,154,653,619	47,099,150,068
7/5/2023	764,147,284	1,700,000,000	445,183,747	2,145,183,747	46,163,297,353
8/5/2023	276,216,731	1,600,000,000	450,882,617	2,050,882,617	44,839,514,084
9/5/2023	1,031,939,205	1,700,000,000	437,953,062	2,137,953,062	44,171,453,289
10/5/2023	50,700,951	1,800,000,000	417,510,997	2,217,510,997	42,422,154,239
11/5/2023	-	1,950,000,000	414,342,411	2,364,342,411	40,472,154,239
12/5/2023	-	1,950,000,000	382,545,020	2,332,545,020	38,522,154,239
1/5/2024	-	1,600,000,000	376,250,630	1,976,250,630	36,922,154,239
2/5/2024	-	1,600,000,000	360,623,233	1,960,623,233	35,322,154,239
3/5/2024	-	1,600,000,000	322,738,039	1,922,738,039	33,722,154,239
4/5/2024	-	1,600,000,000	329,368,438	1,929,368,438	32,122,154,239
5/5/2024	-	1,500,000,000	303,620,362	1,803,620,362	30,622,154,239
6/5/2024	-	1,500,000,000	299,090,356	1,799,090,356	29,122,154,239
7/5/2024	-	1,500,000,000	275,264,198	1,775,264,198	27,622,154,239
8/5/2024	-	1,500,000,000	269,788,986	1,769,788,986	26,122,154,239
9/5/2024	-	1,500,000,000	255,138,301	1,755,138,301	24,622,154,239
10/5/2024	-	1,700,000,000	232,729,951	1,932,729,951	22,922,154,239
11/5/2024	-	1,700,000,000	223,883,506	1,923,883,506	21,222,154,239
12/5/2024	-	1,800,000,000	200,592,965	2,000,592,965	19,422,154,239
1/5/2025	-	900,000,000	189,698,575	1,089,698,575	18,522,154,239
2/5/2025	-	900,000,000	180,908,164	1,080,908,164	17,622,154,239
3/5/2025	-	900,000,000	155,461,196	1,055,461,196	16,722,154,239
4/5/2025	-	900,000,000	163,327,342	1,063,327,342	15,822,154,239
5/5/2025	-	900,000,000	149,551,869	1,049,551,869	14,922,154,239
6/5/2025	-	700,000,000	145,746,520	845,746,520	14,222,154,239
7/5/2025	-	700,000,000	134,428,581	834,428,581	13,522,154,239
8/5/2025	-	700,000,000	132,072,548	832,072,548	12,822,154,239
9/5/2025	-	700,000,000	125,235,561	825,235,561	12,122,154,239
10/5/2025	-	700,000,000	114,579,266	814,579,266	11,422,154,239
11/5/2025	-	700,000,000	111,561,589	811,561,589	10,722,154,239
12/5/2025	-	700,000,000	101,346,389	801,346,389	10,022,154,239
1/5/2026	-	455,552,465	97,887,616	553,440,081	9,566,601,774
2/5/2026	-	455,552,465	93,438,179	548,990,644	9,111,049,308
3/5/2026	-	455,552,465	80,376,928	535,929,394	8,655,496,843
4/5/2026	-	455,552,465	84,539,305	540,091,770	8,199,944,378
5/5/2026	-	455,552,465	77,506,324	533,058,789	7,744,391,912
6/5/2026	-	455,552,465	75,640,431	531,192,896	7,288,839,447



Түрээслэгч

[Signature]

ЭХХ

[Signature]

УБДС

[Signature]

ДҮТ

[Signature]

Огноо	Олгосон	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Нийт төлбөр	Үлдэгдэл
7/5/2026	-	455,552,465	68,894,510	524,446,975	6,833,286,981
8/5/2026	-	455,552,465	66,741,556	522,294,022	6,377,734,516
9/5/2026	-	455,552,465	62,292,119	517,844,585	5,922,182,050
10/5/2026	-	455,552,465	55,976,789	511,529,255	5,466,629,585
11/5/2026	-	455,552,465	53,393,245	508,945,711	5,011,077,120
12/5/2026	-	455,552,465	47,364,976	502,917,441	4,555,524,654
1/5/2027	-	455,552,465	44,494,371	500,046,836	4,099,972,189
2/5/2027	-	455,552,465	40,044,934	495,597,399	3,644,419,723
3/5/2027	-	455,552,465	32,150,771	487,703,237	3,188,867,258
4/5/2027	-	455,552,465	31,146,060	486,698,525	2,733,314,793
5/5/2027	-	455,552,465	25,835,441	481,387,907	2,277,762,327
6/5/2027	-	455,552,465	22,247,185	477,799,651	1,822,209,862
7/5/2027	-	455,552,465	17,223,627	472,776,093	1,366,657,396
8/5/2027	-	455,552,465	13,348,311	468,900,777	911,104,931
9/5/2027	-	455,552,465	8,898,874	464,451,340	455,552,465
10/5/2027	-	455,552,465	4,305,907	459,858,372	-
Нийт	55,822,154,239	55,822,154,239	11,038,270,900	66,860,425,140	-

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

<p>Түрээслүүлэгч талын төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.Цэрэнсодном</p> <p>Ахлах Мэргэжилтэн /Н.Вадрал/</p>	<p>Түрээслэгч талын төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.Мөнхөө</p> <p>Бронхий инженер /Э.Мөнхжаргал/</p>	<p>ЭХЗХ-г төлөөлж: “ЭХЗХ”-НЫ ДАРГА Э.Түвшинчулуун</p> <p>Үнэ тарифын газрын дарга /Б.Эрдэнэбулган/</p>	<p>УБДС-г төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.Баярсайхан</p> <p>Бронхий инженер /Ш.Мөнхжаргал/</p>	<p>ДҮТ-г төлөөлж: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.Балжинням</p> <p>Бронхий инженер /Б.Баатар/</p>
---	---	--	---	---

Санхүүгийн түрээсийн эргэн төлөлтийн хуваарийг хянасан:

Санхүүгийн түрээсийн мэргэжилтэн

Э.Бат-Эрдэнэ Э.Бат-Эрдэнэ

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК
Түрээслүүлэгч
Хуульч


Түрээслэгч

ЭХЗХ

УБДС

ДҮТ

2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр
байгуулсан СТГ-22/01 дугаартай
Санхүүгийн түрээсийн гэрээний
Хавсралт-3



ХӨВӨГЧ ХҮҮ БАТАЛГААЖУУЛАХ НӨХЦӨЛ

20.. оны дүгээр сарын-ны өдөр

Улаанбаатар хот

1. Гэрээний 3.7 (Гэрээний 3.3-т заасны дагуу түрээсийн хууг шинэчлэхтэй холбоотойгоор Гэрээний 3.6-д заасан эргэн төлөлтийн хуваарийг Хавсралт 3-т заасан маягтын дагуу Түрээслүүлэгч болон Түрээслэгч нар тухай бүр баталгаажуулна.)-д заасны дагуу Гэрээний 3.2-т заасан хөвөгч хууг дараах байдлаар шинэчлэх.

1	Шинэчлэн тогтоох SOFR 90 хоногийн хүү% /үсгээр/
2	Мөрдөж эхлэх огноо	20.././..
3	Хүү дахин шинэчлэх огноо	20.././..

2. Энэхүү хавсралт нь Талууд хооронд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан СТГ-22/01 тоот “Санхүүгийн түрээсийн гэрээ”-ний салшгүй хэсэг бөгөөд хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

3. Гэрээний 3.7-д заасны дагуу Хавсралт 2-т заасан эргэн төлөлтийн хуваарийг дараах байдлаар өөрчлөлт оруулж шинэчлэн батлав.

Огноо	Олгосон	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Нийт төлбөр	Үлдэгдэл
...					
...					
...					
...					
...					

НӨХЦӨЛ ТОХИРЧ БАТАЛГААЖУУЛСАН:

Түрээслүүлэгч талыг төлөөлж:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Овог, нэр/

.....

/Албан тушаал/

/Овог, нэр/

.....

Түрээслэгч талыг төлөөлж:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Овог, нэр/



/Албан тушаал/

/Овог, нэр/

.....



Түрээслэгч
ЭХЗ
[Signature]

УБДС
ДУТ
[Signature]